

**"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ПРОТОКОЛ**

2018.03.28

№ 01

Хэрлэн сум

"Адуунчулуун" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тус компанийн хурлын танхимд 2018 оны 03 дүгээр сарын 28-ний өдрийн 14 цаг 22 минутанд хийлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Шинэтогтох хурлыг нээж, хуралд ирвэл зохих 3151304 ширхэг хувьцаа эзэмшигчээс 2753369 хувьцаа эзэмшигч цугларч, хурлын ирц 87.4 %-тай байгааг мэдэгдэж, хурлын ирц хангалттай эсэхийг хэлэлцүүлэн, хурлыг хүчин төгөлдөр гэж үзэн хурлыг эхлүүлэв.

Хурлын тэргүүлэгчээр хэдэн хүн сонгох, хэн хэнийг сонгох санал байгааг хэлэлцүүлэв. Хувьцаа эзэмшигч Ш.Мягмарсүрэн 3 хүн сонгох санал гаргаж, хувьцаа эзэмшигч М.Шинэтогтох, Б.Шатар, Б.Батсайхан нарын нэрийг дэвшүүлэн тоо, нэр бүр дээр санал нэгтэй дэмжиж батлав.

Хурлыг тэргүүлэгч М.Шинэтогтох даргалж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дэс дараалал, дотоод журмыг танилцуулан хэлэлцүүлж санал нэгтэй батлав.

Хурлын тэргүүлэгчээр сонгодсон М.Шинэтогтох тооллогын комиссыг хэдэн хүний бүрэлдэхүүнтэй, хэн хэнийг сонгох талаар санал асуухад хувьцаа эзэмшигч Д.Шинэбаяр 3 хүний бүрэлдэхүүнтэй, Э.Баяржаргал, Б.Алтанцэцэг, Б.Лайжийханд нарыг санал болгов. Ингээд тооллогын комисст Э.Баяржаргал, Б.Алтанцэцэг, Б.Лайжийханд нарыг санал нэгтэй дэмжив.

Хурлын тэргүүлэгч тооллогын комисс томилсон ТУЗ-ийн тогтоолыг танилцуулж, тооллогын комисс ажилдаа оров.

Хурал хэлэлцэх асуудлын дараалал ёсоор илтгэгчид тайлан тавив.

Үүнд:

1. "Адуунчулуун" ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, 2018 оны төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захирал Б.Шатар уншиж танилцуулав.
М.Шинэтогтох: Тайлан тавьсан Гүйцэтгэх захиралдаа баярлалаа. Асууж тодруулах зүйл байна уу?

Ш.Бямбасүрэн: Асуулт асууя? 2017 онд нүүрсний төлөвлөгөө 85%, хөрснийх 90% гэсэн байна. Яагаад 100% биелээгүй вэ?

Б.Шатар: Станцны нүүрсний төлөвлөгөө тасарсан юм. Станц нүүрсээ 7,8,9-р сард МАК-ийн нүүрсийг авч туршиж, хэрэглэсэн учраас манайх 54,0 мян,тн нүүрсний зөрүү гараад 560,0 сая төгрөгийн борлуулалт алдсан байгаа. Хөрс 271,0 м³ төлөвлөсөн боловч, цаг агаарын нөхцөлөөс болоод зогсоод 171,0 м³-р тасалдсан байгаа.

Ш.Бямбасүрэн: 2018 онд нүүрсний төлөвлөгөө биелэхгүй байх баталгаа байна уу? Түүний эсрэг удирдлагын зүгээс авч байгаа арга хэмжээ юу байна?

Б.Шатар: 2018 онд Станцтай аж ахуйн гэрээний дагуу 521,0 тн нүүрс нийлүүлнэ гэсэн гэрээтэй. Станц гэрээгээ мөрдөж ажиллах байх. Ахуй хэрэгцээнд бол өнгөрсөн оныхтой хариуцуулбал өссөн байгаа. Манай нүүрсийг авч хэрэглэх сонирхолтой байдаг.

Ш.Бямбасүрэн: 2018 оны төлөвлөгөөг ер нь ярьчлаа. Ер нь стратеги төлөвлөгөө гэж байна уу? Гумаатын бордоо, шингэн түлш, эд нарын эдийн засгийн тооцоо, үр ашгийн талаар?

Б.Шатар: Уул уурхайн өөрийнх нь ажлын технологи журам гэж байна. Энэ дээр ил уурахд яаж яаж ажиллах вэ гэсэн технологийн дүрэм журмийг нь мөрдөж ажиллаач гээд байгаа юм. Төлбөр тооцоо төсөв төсөл гэж байхгүй. Аливаа улс оронд нэвтрээд явж байгаа, энэ уурхайн нүүрсийг хийжүүлэхэд, шингэн түлш гаргахад хамгийн тохиромжтой юм. Харин одоо хийж хэрэгжүүлэх талаас жоохон аажуураад яваад байгаа. Энийг хийх нь зүйтэй гэж бодож байгаа. Энэ уурхайн алс хэтийн бодлогод гажсан юм бол байхгүй байхаа бодож байна.

Б.Батсайхан: Надад хэлэх юм байна. ТУЗ-ийн хурал дээр Б.Шатар даргыг нэлээн олон байдлаар шүүмжилж байсан. Уурхайнхаа хөрөнгө оруулалт юм уу, томоохон зүйл дээр мөнгө гаргахгүй байна гэж өмнөх хурал дээр шүүмжилж байсан. Тэр шүүмжлэлийг сонсоод ерөнхий төлөвлөгөөнд санхүүгийн боломж байна гэж тавигдсан байх. Гумаат гэдэг юмыг өмнө нь танай уурхай хийгээд,үзээд,туршаад болоод байсан учраас, хийж чадаж байгаа. Уурхайнхаа ганц нүүрс өгөхөөс гадна, яаж эдийн засгаа солонгоруулж, яаж өөр зүйлээс мөнгө олж болох вэ гэж бодох хэрэгтэй байна.

М.Шинэтогтох: За Ерөнхий санхүүч тайлангаа уншиж танилцуулна.

2. "Адуунчулуун" ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар уншиж танилцуулав.

3. 2017 оны ТУЗ-ийн дүгнэлт, ногдол ашиг хувиарлах талаар ТУЗ-ийн дарга М.Шинэтогтох уншиж танилцуулав.

М.Шинэтогтох: Тавигдсан тайлангуудаас асууж лавлах, санал шүүмжлэл, тодруулах зүйл бий эсэх талаар хувьцаа эзэмшигчдээс асууж хариулахыг мэдэгдэв.

Өөр асуулт, санал байхгүй бол дараагийн асуудал болох ногдол ашгийн талаар танилцуулъя. 2017 онд компани 435,5 сая.төг-ийн цэвэр ашигтай ажилласан иймд ТУЗ-с нэгж хувьцаанд 130 төгрөг, нийт дүнгээр 409669520 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан. Хувьцаа эзэмшигчид бүгд гараа өргөж санал нийлж буйгаа илэрхийлэв.

М.Шинэтогтох: Хувьцаа эзэмшигчдэд өөр асуулт, санал, шүүмжлэл байхгүй тул хурлын тэргүүлэгч тооллогын комиссын тогтоол, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолуудын төслүүдийг уншиж хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэн санал нэгтэй батлуулав.

ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны саналаар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгох гишүүдийн нэрсийг танилцууллаа. ТУЗ-ийн ердийн гишүүнээр: Б.Шатар, Б.Батсайхан, Ш.Мягмарсүрэн, Ш.Бямбасүрэн, Ш.Баясгалан, Ш.Идэр, хараат бус гишүүнээр: М.Шинэтогтох, Б.Алтанцэцэг, С.Бадарч нарын нэрсийг дэвшүүлж санал хураав. Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналыг авч сонголоо.

Хурлын дарга М.Шинэтогтох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцэх асуудлаа хурлын дотоод журмын дагуу амжилттай хэлэлцэж дууссан тул хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ДАРГА



М.ШИНЭТОГТОХ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.БАТЧИМЭГ